



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20²¹ он 04 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар ХЭГ/958

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
Г.ЗАНДАНШАТАР ТАНАА

Мэдээлэл хүргүүлэх тухай

Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы 2021 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн нэгдсэн хуралдаанд хийх “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн явцын талаарх мэдээллийг хүргүүлж байна.

Хавсралт ¹ хуудастай.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Ц.НЯМДОРЖ

000021505851

“ЭРҮҮЛ МЭНДЭЭ ХАМГААЛЖ, ЭДИЙН ЗАСГАА СЭРГЭЭХ 10 ИХ НАЯДЫН ЦОГЦ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫН ТАЛААР УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД ХИЙХ МЭДЭЭЛЭЛ

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахалтай тэмцэх, иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, эдийн засгаа сэргээх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө”-г 2021 оны 42 дугаар тогтоолоор **56 арга хэмжээтэйгээр** батлан хэрэгжүүлж байна.

Энэхүү цогц төлөвлөгөөнд иргэдийн эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг бүрдүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих, ажлын байрыг хадгалах, иргэдийг орон сууцжуулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, малчдын орлого, амьжиргааг дэмжих болон уул уурхайн бус экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, иргэн, аж ахуйн нэгжид олгох зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх ажлуудыг тусгасан.

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 4 дүгээр сард баталсан Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, 7.1.5, 7.1.23, 7.1.25, 7.1.26-д Засгийн газар:

- цар тахлын үед иргэний эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, хорио цээрийн болон хязгаарлалтын дэглэмд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх зорилгоор жилийн батлагдсан төсвийн нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсвийн ерөнхийлөн захирагч хооронд, хөрөнгийн болон урсгал зардал хооронд төсвийн зохицуулалт хийх;
- цар тахлын үед хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн улмаас үйл ажиллагаа нь доголдсон аж ахуйн нэгж, байгууллага, цалин, орлого нь тасалдсан иргэдэд зохих дэмжлэг үзүүлэх;
- цар тахлын үед хүн амыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, вакцин, эм, эмнэлгийн хэрэгслээр тэгш хүртээмжтэй хангах;
- үр тарианы болон хүнсний ногооны үрийн нөөц бүрдүүлэх, газар тариалангийн ургац тасалдахаас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах;
- экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх, тэдгээрийн үйл ажиллагаанд төрийн хяналт тавихаар тус тус заасныг удирдлага болгон иргэдийнхээ эрүүл мэндийг хамгаалахын зэрэгцээ эдийн засгаа сэргээх төлөвлөгөөг баталсан.

Халдварт цар тахлын улмаас 2020 онд эдийн засгийн бодит өсөлт -5.3 хувь болж буурсан, төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь 12 хувь болж нэмэгдсэн, зах зээлийн тодорхойгүй байдлын улмаас банкуудаас олгох зээлийн хэмжээ буурч, банкуудын нийт 8.0 их наяд төгрөгийн эх үүсвэр Төв банкны үнэт цаасанд байршсан байсан бөгөөд 2020 онд нийт 65-68.9 мянган ажлын байр алдагдаж, цаашид эдийн засгаа сэргээх арга хэмжээ авч хэрэгжүүлэхгүй тохиолдолд нэмж 130.0 мянган ажлын байр алдах эрсдэлтэй байлаа.

Иймд Засгийн газраас батлан хэрэгжүүлж байгаа төлөвлөгөөний хүрээнд эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг цар тахлын өмнөх түвшинд буюу эдийн засгийн өсөлтийг 5.2 хувиас багагүй түвшинд хүргэн сэргээх, ажлын байрыг дэмжихийн зэрэгцээ инфляц, гадаад валютын албан нөөцийг мөнгөний бодлогын

зорилтот түвшинд барих зорилт тавьж байна. Түүнчлэн, ажлын байрыг дэмжих зээлийн хүрээнд нийт 3,500 аж ахуйн нэгж, 20,000 иргэнд зээл олгож, 120 мянган ажлын байрыг дэмжихээр тооцсон.

Төлөвлөгөөнд тусгагдсан ажлын байрыг дэмжих зээл, Төв банкны репо санхүүжилтийн зээл болон ипотекийн зээлээр нийт 852.7 тэрбум төгрөгийн зээл олгоод байна. Ажлын байрыг дэмжих зээл болон репо санхүүжилттэй зээлд хамрагдсан нийт 6.9 мянган зээлдэгчийн 30.9 мянган ажлын байрыг хамгаалж, 2,609 зээлдэгч 195.6 тэрбум төгрөгийн ипотекийн зээл авч, орон сууцтай болсон байна.

Нэг. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийн талаар

Монгол Улсын Засгийн газар “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө”-г боловсруулахдаа улсын төсөв, Засгийн газрын өрд дарамт үүсгэхгүй байх зарчим баримталсан бөгөөд төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудаас ажлын байрыг дэмжих зээл, хөдөө аж ахуйг дэмжих зээлийг банкуудын өөрийн эх үүсвэрээр хэрэгжүүлж, Засгийн газраас хүүгийн дэмжлэг олгохоор, репо санхүүжилттэй зээл болон ипотекийн зээлийг банк болон Төв банкны репо санхүүжилтийн эх үүсвэрээр хэрэгжүүлнэ.

“Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө”-ний үндсэн зорилт нь банк, санхүүгийн байгууллагаас олгох зээлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, Зээлийн батлан даалтын тогтолцоог ашиглан банкуудын эрсдэлийг хуваалцах, Засгийн газраас батлагдсан төсвийн хүрээнд зээлдэгчийн төлөх хүүгийн тодорхой хувийг хариуцан төлөх замаар зээлдэгчийн санхүүгийн дарамтыг зөөллөхөөр тооцсон бөгөөд нөгөө талаас улсын төсөвт тусгагдан гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслүүдийн санхүүжилтийг эрчимжүүлэх замаар эдийн засгийн идэвхжлийг бий болгохоор төлөвлөгөөнд тусгасан. Мөн “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн бүтээн байгуулалтын төсөл болон эдийн засгийн хувьд үр ашигтай бусад төслүүдийг улсын төсөв, Засгийн газрын өрийн хязгаарт дарамт үзүүлэхгүйгээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн болно.

Хүснэгт 1. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэр

Төлөвлөгөөний үндсэн ажил /хэрэгжих хугацаа/	Төлөвлөгөө	Санхүүжилтийн эх үүсвэр, хэрэгжүүлэх арга зам
	тэрбум ₮	
Ажлын байрыг дэмжих зээл /2021 он/	2,000.0	Банкны эх үүсвэрт тулгуурлан ААН-д олгосон зээлд 6 хувь, иргэнд олгосон зээлд 7 хувийн хүүгийн дэмжлэг олгоно. 2021 оны хүүгийн дэмжлэгийг батлагдсан төсвийн зардлыг нэмэгдүүлэхгүй төсвийн зохицуулалт хийж санхүүжүүлнэ, 2022 оноос гарах хүүгийн дэмжлэгийг жил бүрийн төсөвт тусгана.
Ипотекийн зээл /2021-2022 он/	2,000.0	Монголбанк болон банкуудын холимог эх үүсвэрээр санхүүжүүлнэ. Төсөвт нэмэлт ачаалал үүсгэхгүй.
Репо санхүүжилтийн зээл /2021 он/	2,000.0	Монголбанкны репо санхүүжилтийн эх үүсвэр. Төсөвт нэмэлт ачаалал үүсгэхгүй.
Хөдөө аж ахуйн зээл /2021 он/	500.0	Банкны эх үүсвэрт тулгуурлан зээлийн хүүгийн 7.65 хүртэл хувьд төсвийн дэмжлэг өгөх замаар хэрэгжүүлнэ. 2021 оны хүүгийн дэмжлэгийг батлагдсан төсвийн зардлыг нэмэгдүүлэхгүй төсвийн зохицуулалт хийж санхүүжүүлнэ, 2022 оноос гарах хүүгийн дэмжлэгийг жил бүрийн төсөвт тусгана.

Орон сууцны хорооллын дэд бүтэц /2021-2024 он/	1,000.0	“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хийх бүтээн байгуулалтын ажлыг дотоодын үнэт цаасны зах зээлд бонд гаргах замаар санхүүжүүлж, бусад гадаадын зээл, тусламжийн төслүүд болон залуусыг хөдөлмөрт бэлтгэх сургалтыг жил бүрийн батлагдсан төсвийн хүрээнд хэрэгжүүлнэ. Санхүүгийн хувьд үр ашигтай арилжааны шинж чанартай төслүүдийг төсөв, Засгийн газрын өрд дарамтгүй хэлбэрээр хэрэгжүүлэх зохион байгуулалтыг хийхээр төлөвлөсөн.
Залуусыг хөдөлмөрт бэлтгэх сургалт /2021-2024 он/	500.0	
Том төслүүдийн санхүүжилт /2021-2024 он/	2,000.0	
НИЙТ	10,000.0	

“Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 их наядын цогц төлөвлөгөө”-ний дараах хөтөлбөрүүдийн хүрээнд Засгийн газар хүүгийн дэмжлэг олгохоор шийдвэрлэсэн. Үүнд:

- Ажлын байрыг дэмжих зээлийн хүрээнд 2.0 их наяд төгрөг хүртэлх зээлийг 3 жилийн хугацаатай, жилийн 3 хувийн хүүтэйгээр аж ахуйн нэгж, иргэнд олгох бөгөөд тус зээлийн хүрээнд аж ахуйн нэгжид олгосон зээлийн хүүгийн 6.0 хувь, иргэнд олгосон зээлийн хүүгийн 7.0 хувьд;
- Хаврын тариалалтад зориулан олгох 100.0 тэрбум төгрөг, ноолуур бэлтгэлийн үйл ажиллагаанд зориулан олгох 200.0 тэрбум төгрөг, нийт 300.0 тэрбум төгрөгийн зээлийн хүрээнд 1 жилийн хугацаатай, жилийн 3.0 хувийн хүүтэй зээлийг олгох бөгөөд зээлийн хүүгийн 7.65 хүртэлх хувьд;
- Малчдыг дэмжих 200.0 тэрбум төгрөгийн зээлийн хүрээнд 3 жилийн хугацаанд жилийн 3.0 хувийн хүүтэй зээлийг банк, санхүүгийн байгууллагаар дамжуулан олгох бөгөөд зээлийн хүүгийн 7.0 хувьд хүүгийн дэмжлэгийг тус тус үзүүлнэ.

Ажлын байрыг дэмжих зээл, Хөдөө аж ахуйг дэмжих зээлийн хүрээнд Засгийн газар 2021-2024 оны хооронд нийт 315.4 орчим тэрбум төгрөгийн хүүгийн дэмжлэгийг иргэн, аж ахуй нэгжүүдэд олгохоор байна.

Энэхүү хүүгийн дэмжлэгт 2021 онд шаардагдах зардлыг “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”-ийн 7.1.2, Төсвийн тухай хуулийн 42.2.1а-д тус тус заасны дагуу 2021 оны батлагдсан зардлын хүрээнд зохицуулалт хийж санхүүжүүлнэ. Харин 2022-2024 онд олгох хүүгийн дэмжлэгийн зардлыг Монгол Улсын 2022-2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл болон тухайн онуудын Төсвийн тухай хуульд тусган санхүүжүүлэх юм.

Түүнчлэн Зээлийн батлан даалтын сангийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор гаргасан үнэт цаасны төлбөрт жил бүр 5 тэрбум төгрөгийг 10 жилийн хугацаанд улсын төсвөөс төлөх бөгөөд энэ нь төсөвт харьцангуй бага ачаалал үүсгэж, ажлын байрыг дэмжих зээлд хамрагдсан, барьцаа хөрөнгийн дутагдалтай аж ахуйн нэгжүүдэд нийт 1.0 их наяд төгрөг хүртэл зээлийн батлан даалт гаргах нөхцөлийг бүрдүүлнэ.

Өөрөөр хэлбэл, эдийн засгийг сэргээх хүрээнд нийт 6.5 их наяд төгрөгийн бага хүүтэй зээл олгогдох бөгөөд Засгийн газраас 2021-2024 онуудад жилд дунджаар 70-80 тэрбум төгрөг зарцуулж, энэ нь бага хүүтэй зээл авсан аж ахуйн нэгж, иргэд, малчдад санхүүгийн дэмжлэг болж, бизнесийн хэвийн үйл ажиллагаа хангагдана гэж үзэж байна.

Хоёр. Төлөвлөгөөний нийгэм, эдийн засагт үзүүлэх үр дагавар

2.1. Эдийн засгийн байдал

Төсвийн гүйцэтгэл: Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 2021 оны 2 дугаар сарын гүйцэтгэлээр 1,627.6 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 15.9 хувиар буюу 258.3 тэрбум төгрөгөөр илүү байна. Эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр аж ахуй нэгжийн орлогын албан татвараар 469.3 тэрбум төгрөг төсөвт төвлөрсөн нь өмнөх оны мөн үеэс 41 хувиар, нэмэгдсэн өртгийн албан татвараар 711.1 тэрбум төгрөг төвлөрсөн нь өмнөх оны мөн үеэс 30 хувиар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрт 262.1 тэрбум төгрөг төвлөрсөн нь өмнөх оны мөн үеэс 18 хувиар тус тус илүү байна. Дотоодын эдийн засгийн үйл ажиллагааны хязгаарлалтыг сулруулж, хөл хориог цуцалсан нь эдийн засгийн идэвхжилтэд эерэг нөлөө үзүүлснээр төсвийн орлого сэргэж эхэлж байна.

Гадаад худалдааны гүйцэтгэл: 2021 оны эхний 2 сард экспортын хэмжээ 1.3 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 73 хувиар, импортын хэмжээ 0.9 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 23 хувиар өссөн байна. Гадаад худалдааны тэнцэл 2021 оны эхний 2 сард өмнөх оны мөн үеэс 391.6 сая ам.доллараар өсөж, 412.3 сая ам.долларын ашигтай гарлаа.

Инфляц: Хэрэглээний үнийн индексээр тооцсон жилийн инфляц улсын хэмжээнд 2021 оны 2 дугаар сарын байдлаар 2.6 хувь байна. Эдийн засгийн үйл ажиллагаа идэвхжиж байгаатай холбоотойгоор инфляц сүүлийн хоёр сард өсөж эхэлж байгаа хэдий ч зорилтот түвшнээс бага хэвээр байна.


Мөнгөний нийлүүлэлт: Мөнгөний нийлүүлэлт 2021 оны 2 дугаар сарын байдлаар 24.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 19.6 хувиар өссөн байна. Мөнгөний өсөлтийн хурд нь өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн байгаа ч 2019 оны мөн үед мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт 23.1 хувь байсантай харьцуулахад бага хэмжээнд байна.

Хүснэгт 2. Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд

МАКРО СУУРЬ ҮЗҮҮЛЭЛТҮҮД	Харьцуулах үзүүлэлт		2021 оны дурьдсан хугацаанд	Зөрүү /2019 оноос/
	2019 оны мөн үе	2020 оны мөн үе		
Нэгдсэн төсвийн нийт орлого, тэрбум ₮, 2 дугаар сар	1,638.1	1,464.4	1,720.6	82.5
НӨАТ-ын орлого, тэрбум ₮	382.9	356.4	421.9	39.0
Гадаад худалдааны тэнцэл, сая \$, 2 дугаар сар	256.1	20.7	412.3	156.2
Экспорт	1,093.6	770.7	1,334.6	241.0
Импорт	837.5	750.0	922.3	84.8
Улсын инфляц, жилийн өөрчлөлт %, 2 дугаар сар	6.9	6.4	2.6	(4.3)
Нийт мөнгөний жилийн өөрчлөлт, %, 2 дугаар сар	23.1	5.2	19.6	(3.5)
Төв банкны үнэт цаасны үлдэгдэл, тэрбум ₮, 2021/04/05	5,835.4	5,087.0	8,058.0	2,222.6
Бүртгэлтэй ажилгүй иргэд, 2 дугаар сар	24,023.0	20,643.0	15,462.0	(8,561.0)
Ам.долларын ханш, ₮, өөрчлөлт, 2021/04/05	2,631.6	2,779.8	2,849.8	218.2
Төлөвлөгөөний хүрээнд олгосон зээл, тэрбум ₮, 2021/04/06			786.2	-
Зээлдэгчдийн тоо			9,301.0	-
Зээлдэгчдийн ажлын байр			30,737.0	-

Төв банкны үнэт цаасанд 2021 оны 3 дугаар сарын 22-ний өдөр 8.9 их наяд төгрөг байршиж байсан бол 4 дүгээр сарын 5-ны өдрийн байдлаар 8.1 их наяд төгрөг болж, 850 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 1. Төв банкны үнэт цаасны үлдэгдлийн хөдөлгөөн



2.2. Макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн төсөөлөл

“Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө”-г хэрэгжүүлснээр макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг 2019 оны түвшинд хүргэж сэргээх зорилт тавьж байна.

Төлөвлөгөөг хэрэгжүүлснээр **2021 оноос бизнесийн идэвхжил сэргэж, эдийн засгийн өсөлт 5.2 хувиас давахаар төсөөлөлтэй** байна. Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг **2022-2024 онд урт хугацааны өсөлтийн түвшинд буюу 6 орчим хувьд** хүргэхээр зорьж байна.

Цогц төлөвлөгөөний хүрээнд бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжүүдэд бага хүүтэй зээл олгож байгаа нь бизнесийн зардлыг бууруулж, нийлүүлэлтийн гаралтай инфляцын дарамтыг бууруулахад чухал нөлөөтэй байна. **Инфляцын түвшин дунд хугацаанд буюу 2022-2024 онд 6 орчим хувьд байхаар байна.**

Зураг 2. Макро эдийн засгийн зарим үзүүлэлтүүдийн төсөөлөл



Эдийн засгийн идэвхжил сэргэж, уул уурхай, барилга, боловсруулах үйлдвэрлэл зэрэг салбаруудын үйл ажиллагаа сэргэхээр байгаа нь авто бензин, дизель түлш, барилгын материал, үйлдвэрлэлийн орц, тоног төхөөрөмж, тэдгээрийн эд ангийн импортыг нэмэгдүүлэхээр байна. Ингэснээр дунд хугацаанд гадаад худалдааны ашиг буурч болзошгүй байна.

Гурав. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн талаар

3.1. Ажлын байрыг дэмжих зээл

Ажлын байрыг дэмжих зорилтын хүрээнд нийт **2.0 их наяд** хүртэлх төгрөгийн хүүгийн хөнгөлөлттэй зээлийг арилжааны банкуудын санхүүгийн чөлөөт эх үүсвэрт тулгуурлан олгож эхлээд байна. Тус зээлийн бүтээгдэхүүн нь зээлдэгч талдаа жилийн 3 хувийн хүүтэй, 3 жилийн хугацаатай, 1 жил үндсэн зээлийнхээ төлбөрөөс чөлөөлөгдөх нөхцөлтэй юм.

Засгийн газраас аж ахуйн нэгжид олгосон зээлийн хүүгийн 6 нэгж хувийг, иргэдэд олгосон зээлийн 7 нэгж хувийг хариуцан төлөх бөгөөд барьцаа хөрөнгийн дутагдалтай үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдэд 60 хүртэлх хувийн батлан даалтыг Зээлийн батлан даалтын сангаар дамжуулан гаргаж болохоор зохицуулан хэрэгжүүлж байна.

Сангийн яам, Монголбанк, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Зээлийн батлан даалтын сан, арилжааны 10 банк хооронд 2021 оны 3 дугаар сарын 5-ны өдөр “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-д тусгагдсан “Ажлын байрыг дэмжих зээл”-ийн Санхүүжилтийн ерөнхий гэрээ”-г байгуулсан ба банкууд зээлийн хүсэлтийг 2021 оны 2 дугаар сарын 24-ний өдрөөс хүлээн авч эхэлсэн.

Хүснэгт 3. Зээл олголт

2021.04.06-ны өдрийн байдлаар, тэрбум ₮

Нийт дүн	Тоо	Үүнээс:								Зээлийн батлан даалт, сая ₮		Зээлдэгчийн ажлын байр	
		ААН		Иргэн		Улаанбаатар		Орон нутаг		Дүн	Тоо	УБ	Орон нутаг
		Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо				
369.3	5,525	192.9	814	176.4	4,711	177.3	1,993	191.9	3,532	596.6	6	11,838	5,314

Эх үүсвэр: Монголбанкны 2021 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн мэдээ

Хүснэгт 4. Зээлийн хүсэлт шийдвэрлэлт

2021.04.06-ны өдрийн байдлаар, тэрбум ₮

Зээлийн хүсэлт	Дүн	Тоо	Үүнээс:							
			ААН		Иргэн		Улаанбаатар		Орон нутаг	
			Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
Ирсэн хүсэлт	4,982.1	36,344	4,075.5	13,839	906.7	22,505	3,099.2	16,125	3,228.4	20,219
Татгалзсан	318.0	1,726	276.6	913	41.3	813	246.2	1,033	71.7	693
Судалгаанд байгаа	1,678.8	11,034	1,415.2	4,505	263.6	6,530	1,199.8	6,235	479.0	4,799

Эх үүсвэр: Монголбанкны 2021 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн мэдээ

2021 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн байдлаар нийт **4,982.1 тэрбум** төгрөгийн **36.3 мянган** зээлийн хүсэлт ирүүлснээс **369.3 тэрбум** төгрөгийг **5,525** (814 аж ахуйн нэгж, 4711 иргэн) зээлдэгчид олгоод байна. Нийт ирүүлсэн зээлийн хүсэлтээс судалгаанд байгаа 1,678.8 тэрбум төгрөгийн 11,034 хүсэлт, татгалзсан 318.0 тэрбум төгрөгийн 1,726 хүсэлт байна.

Иргэдийн авсан зээлийн дундаж хэмжээ **37.4 сая** төгрөг, аж ахуйн нэгжийн авсан дундаж зээлийн хэмжээ **237.0 сая** төгрөг байна.

3.2. Монголбанкны урт хугацаат репо санхүүжилттэй зээл

Монголбанкнаас дэлхийн бусад улс, орнуудын төв банкуудын Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед хэрэгжүүлж байгаа сайн туршлагыг судалж, зээлийг багцлан үнэт цаасжуулан репо нөхцөлөөр санхүүжилт олгох механизмыг 2020 оны 4 дүгээр улиралд нэвтрүүлсэн байна. Уг арга хэмжээний хүрээнд Монголбанкнаас 2 жил хүртэл хугацаатайгаар банкнуудад репо нөхцөлөөр санхүүжилт олгож, банкууд эцсийн зээлдэгчид 10.5 хувийн хүүтэйгээр шинээр зээл олгох, олгосон зээлийг дахин санхүүжүүлэх арга хэмжээ авч байна.

Хүснэгт 5. Зээл олголт

2021.04.06-ний өдрийн байдлаар, тэрбум ₮

Зээлийн дүн	Зээлдэгч	Үүнээс:								Зээлдэгчийн ажлын байр	
		ААН		Иргэн		Улаанбаатар		Орон нутаг		УБ хот	Орон нутаг
		Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо		
221.3	1,467	174.8	1,103	46.5	364	167.4	945	53.8	522	10,188	3,549

Эх үүсвэр: Монголбанкны 2021 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн мэдээ

Хүснэгт 6. Зээлийн хүсэлт шийдвэрлэлт

2021.04.06-ны өдрийн байдлаар, тэрбум ₮

Зээлийн хүсэлт	Дүн	Тоо	Үүнээс:							
			ААН		Иргэн		Улаанбаатар		Орон нутаг	
			Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
Ирсэн хүсэлт	476.6	2,204	381.8	1,515	94.8	689	386.3	1,471	90.2	733
Татгалзсан	70.3	347	57.7	218	12.6	129	58.2	246	12.0	101
Судалгаанд байгаа	185.0	390	149.3	190	35.7	196	160.7	280	24.3	110

Эх үүсвэр: Монголбанкны 2021 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн мэдээ

2021 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн байдлаар нийт **476.6 тэрбум** төгрөгийн **2,204** зээлийн хүсэлт ирүүлснээс **221.3 тэрбум** төгрөгийг **1,467** (1103 аж ахуйн нэгж, 364 иргэн) зээлдэгчид олгоод байна. Нийт ирүүлсэн хүсэлтээс судалгаанд байгаа 185.0 тэрбум төгрөгийн 390 хүсэлт, татгалзсан 70.3 тэрбум төгрөгийн 347 хүсэлт байна.

Иргэдийн авсан зээлийн дундаж хэмжээ **150.8 сая** төгрөг, аж ахуйн нэгжийн авсан дундаж зээлийн хэмжээ **158.5 сая** төгрөг байна.

3.3. Орон сууцны ипотекийн зээл

Орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөр нь агаар, орчны бохирдлыг бууруулах үндсэн зорилгын хүрээнд бага, дунд орлоготой иргэдийг орон сууц ипотекийн хөнгөлөлттэй зээлд хамруулах, тэдгээрийг орон сууцжуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх явдал юм.

Хөтөлбөрийн хүрээнд зээл олголтын нөхцөлийг хөнгөвчилж, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Монголбанк 2020 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хүүг жилийн 6 хувь болгон бууруулсан. Уг зээлийг Монголбанк болон банкуудын холимог эх үүсвэртэйгээр хэрэгжүүлж байна.

Хүснэгт 7. Зээл олголт

2021.04.06-ны өдрийн байдлаар, тэрбум ₮

Дүн /тэрбум ₮/			Зээлдэгчийн тоо			Үүнээс:					
						Улаанбаатар		Орон нутаг		Шинэ зээл	Дахин санхүүжилт
МБ-ын эх үүсвэртэй	Банкны эх үүсвэртэй	Нийт	МБ-ын эх үүсвэртэй	Банкны эх үүсвэртэй	Нийт	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Дүн
114.4	81.2	195.6	1,718	891	2,609	156.5	1,895	39.1	714	181.0	14.6

Эх үүсвэр: Монголбанкны 2021 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн мэдээ

Хүснэгт 8. Зээлийн хүсэлтийн шийдвэрлэлт

2021.04.06-ны өдрийн байдлаар, тэрбум ₮

Зээлийн хүсэлт	Дүн /тэрбум ₮/	Тоо	Үүнээс:			
			Улаанбаатар		Орон нутаг	
			Дүн	Тоо	Дүн	Тоо
Ирсэн хүсэлт	542.8	6,963	471.3	5,625	71.4	1,338
Татгалзсан	123.4	1,596	107.0	1,295	16.4	301
Судалгаанд байгаа	216.2	2,885	180.5	2,216	35.7	669

Эх үүсвэр: Монголбанкны 2021 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн мэдээ

2021 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн байдлаар нийт **542.8 тэрбум** төгрөгийн **6,963** зээлийн хүсэлт ирүүлснээс **195.6 тэрбум** төгрөгийг **2,609** зээлдэгчид олгоод байна. Нийт ирүүлсэн хүсэлтээс судалгаанд байгаа 216.2 тэрбум төгрөгийн 2,885 хүсэлт, татгалзсан 123.4 тэрбум төгрөгийн 1,596 хүсэлт байна.

Иргэдийн авсан зээлийн дундаж хэмжээ **75.0 сая** төгрөг, үүнээс Улаанбаатар хотод олгосон зээлийн дундаж **82.6** сая төгрөг, орон нутагт **54.7** сая төгрөг байна.

3.4. Эрүүл мэндээ хамгаалах арга хэмжээ

Коронавируст халдвар (КОВИД-19)-ыг эрт илрүүлэх, голомтыг хумих, вакцинжуулалтын бэлтгэл ажил, нийгэм-эдийн засгийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор 2021 оны 2 дугаар сарын 8-22-ны өдрүүдэд төрийн болон нийслэлийн нутгийн захиргааны ажилтан, албан хаагч, голомтын бүсчилсэн, өргөтгөсөн тандалт, шинжилгээнд 411,420 иргэнийг хамруулахаар төлөвлөснөөс 504,949 иргэнийг хамруулж, 118.5 хувийн гүйцэтгэлтэй зохион байгуулсан.

“Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээнд давхардсан тоогоор эрүүл мэндийн ажилтан 7279, нутгийн захиргааны байгууллагын ажилтан, албан хаагч 5849, нийт 13128 хүн дайчлагдан ажилласан. Мөн мэргэжлийн хяналтын байгууллагаас 600 албан хаагч ажиллаж, нийт 1672 зөрчил илрүүлж, зөрчлийн 75 хувийг газар дээр арилгуулан, шинжилгээний суурин болон явуулын цэг, тусгаарлан ажиглах байр, худалдаа, үйлчилгээний байгууллагуудад эрүүл ахуйн нөхцөл, халдвар хамгааллын дэглэм, тусламж үйлчилгээний чанар, аюултай хог хаягдлын аюулгүй байдалд хяналт тавьж ажилласнаар халдвар дамжин тархах эрсдэлээс урьдчилан сэргийлсэн.

2021 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн байдлаар Монгол Улсад коронавируст халдвар (КОВИД-19)-ын нийт **12,226 батлагдсан тохиолдол** бүртгэгдсэнээс дотоодын халдвар **11,680** (Улаанбаатар хотод 10093, орон нутагт 1587), зөөвөрлөгдсөн **427**, эрүүл мэндийн салбарын **119** тохиолдол байна.

Улсын хэмжээнд тусгаарлан ажиглах 112 байранд Монгол Улсын 3,268, гадаад улсын 113, нийт 3,381 иргэн байна. 2021 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн байдлаар Улаанбаатар хотод 452,620 иргэн, орон нутагт 77,291 иргэн, улсын хэмжээнд нийт 529,911 иргэнийг коронавируст халдварын эсрэг вакцины эхний тунд хамруулаад байна.

Хүснэгт 9. Вакцины нөөц

2021.04.07-ны өдрийн байдлаар

Вакцины нэр, үйлдвэрлэгч улс	Татан авсан тоо	Үлдэгдэл
AstraZeneca / БНЭУ + КОВАКС	164,400	64,730
Синофарм / БНХАУ	600,000	16,077
Спутник V / ОХУ	20,000	-
Pfizer-BioNTech / КОВАКС	25,740	19,250
Нийт	810,140	100,057

Улсын хэмжээнд коронавируст халдварын үед шаардлагатай 36 нэр төрлийн нийт 5.2 тэрбум төгрөгийн эмийн нөөцтэй байгаагаас эрүүл мэндийн байгууллагад 2.4 тэрбум төгрөгийн эмийн нөөц, Эрүүл мэндийн яаманд 2.8 тэрбум төгрөгийн эмийн нөөц тус тус байна.

Улсын хэмжээнд 6 нэр төрлийн 3.4 тэрбум төгрөгийн вирусийн эсрэг, 9 нэр төрлийн 594.5 сая төгрөгийн антибиотик, 5 нэр төрлийн 498.3 сая төгрөгийн амилуулах тусламж, үйлчилгээний эм, 8 нэр төрлийн 482.0 сая төгрөгийн дуслын шингэн, 6 нэр төрлийн 169.6 сая төгрөгийн шинж тэмдгийн эсрэг эмчилгээний эмийн нөөцтэй байна. Мөн 16 нэр төрлийн нийт 33.5 тэрбум төгрөгийн хувийн хамгаалах хэрэгслийн нөөц, 13 нэр төрлийн нийт 1.2 тэрбум төгрөгийн эмнэлгийн хэрэгслийн нөөцтэй байна.

Оношлуурын нөөц улсын хэмжээнд ПГУ-ийн кит 49006 ширхэг, ПГУ-ийн ялгах кит 77516 ширхэг, GENE EXPERT (Cartridge) 255 ширхэг, хамар залгиурын түргэвчилсэн оношлуур 67839 ширхэг, ийлдэс болон бүхэл цусны түргэвчилсэн оношлуур 6284 ширхэг нөөцтэй байна.

Эрүүл мэндийн байгууллагуудад нийт 984 амьсгалын аппарат (үүнээс зөөврийн 137) ашиглагдаж байна. Үүнээс, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүдэд 501 (үүнээс зөөврийн 30), Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа байгууллагад 231 (үүнээс зөөврийн 77), орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад 252 (үүнээс зөөврийн 60) амьсгалын аппарат байна.

Мөн Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн эрдэмтэд Мюнхений технологийн их сургууль, Японы Каназава их сургуулийн эрдэмтэдтэй хамтран шүлснээс коронавирус илрүүлэх шинэ оношлуур бүтээж хэрэглээнд нэвтрүүлээд байна. Энэхүү оношлуур нь коронавируст халдварыг эрт илрүүлэх өндөр мэдрэг чанартай, шинжилгээ өгч байгаа хүнд зовиургүй, халдварын эрсдэл бага бөгөөд 90 минутын дотор хариу гарч, шинжилгээний зардал 2-3 дахин бага зэрэг давуу талтай юм.

3.5. Залуучуудын хөгжил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ

Залуучуудад эрүүл, эртэч, идэвхтэй амьдралын хэв маяг, эх оронч үзлийг төлөвшүүлэх сургалт зохион байгуулж, ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх замаар хөдөлмөрт бэлтгэж, ажилтай, орлоготой болгох зорилго бүхий Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрийг Засгийн газрын 2021 оны 58 дугаар тогтоолоор батлаад байна.

Хөтөлбөрийн хүрээнд 18-34 насны нийт 5000 залуучуудыг сонгон шалгаруулж, 1 сарын хугацаанд үргэлжлэх багц сургалтад тус бүр 1.0 сая төгрөгийн тэтгэлэгтэйгээр хамруулан сургах юм. Сургалтын үйл явц, үр дүнг олон нийтэд нээлттэй байдлаар сурталчлан мэдээлж, залуучуудын ажил, хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхлыг төрүүлэх, улмаар ажлын байранд дадлагажуулан ажилд зуучлах үйл ажиллагааг зохион байгуулна.

Уг хөтөлбөрийг 2021-2024 онд хэрэгжүүлэх бөгөөд 2021 оны хувьд нийт 5000 залуучуудыг багц сургалтад хамруулахад 11.8 тэрбум төгрөгийг зарцуулахаар төлөвлөж байна. Сургалтаа амжилттай төгссөн залуучуудыг цаашид мэргэжлийн сургалтад үргэлжлүүлэн сургах, ажилд зуучлах үйлчилгээнд хамруулахаас гадна төсөлд хамрагдсан залуучуудыг нэг жилийн хугацаанд тогтвор суурьшилтай ажлын байраар хангасан ажил олгогч болон ажилтанд 1 жилийн нийгмийн даатгалын шимтгэлтэй тэнцэх хэмжээний урамшууллыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож нөхөн олгохоор тусгасан.

Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төслийн хэрэгжилтийг Улсын онцгой комиссоос өгсөн зөвшөөрлийн хүрээнд зохион байгуулахаар төлөвлөж, бэлтгэл ажлыг хангаж байна. Бэлтгэл ажлын хүрээнд сургалтын агуулга, хөтөлбөр боловсруулах ажлыг Удирдлагын академи, мэргэжлийн сургалт, боловсролын үнэлгээний төв болон хүний нөөцийн сургалтын мэргэжилтнүүдийн оролцоотойгоор боловсруулж байна.

3.6. Иргэдээ татан авах, бизнес эрхлэгчид, түншлэгчдийг хүлээн авах арга хэмжээ

2020 оны 2 дугаар сарын 1-нээс 2021 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн байдлаар агаарын замаар 149 нислэг үйлдэж 25,216 иргэн, Монгол-Хятадын боомтоор 4,266 иргэн, Монгол-Оросын боомтоор 2,485 иргэн, нийт 93 орноос 31,967 иргэнээ эх орондоо авчрах ажлыг зохион байгуулсан. 2021 оны 3 дугаар сард агаарын замаар 19 нислэг үйлдэж 2035 иргэн, Монгол-Хятадын боомтоор 6 иргэн, Монгол-Оросын боомтоор 35 иргэн, нийт 2076 иргэдээ татан авсан байна.

Цаашид агаарын хилийг шат дараатай нээх, 5 дугаар сараас эхлэн тогтмол хуваарьт нислэг үйлдэх, гадаадын агаарын тээвэрлэгчийн нислэгийг сэргээх хэлэлцээг хийж байна. Энэ хүрээнд эхний ээлжид 3 дугаар сарын 30-ны өдөр Бүгд Найрамдах Солонгос Улсын агаарын тээвэрлэгчийн нислэгийг хүлээн авсан бол 4 дүгээр сард Бүгд Найрамдах Солонгос Улсын 2, Бүгд Найрамдах Турк Улсын 1 нислэгийг хүлээж авах бэлтгэлийг хангаж байна.

Монгол Улсад ирж ажиллах шаардлагатай бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчдыг хүлээн авах, нэвтрүүлэх асуудлыг шийдвэрлэж, холбогдох визийн зөвшөөрлийг хэвийн горимоор олгож эхэлсэн ба 2021 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс 3 дугаар сарын 30-ны өдрийн хооронд аж ахуйн нэгжийн шугамаар Монгол

Улсад богино хугацаагаар ирэх 45 иргэнд В /бизнес/ ангиллын визийн зөвшөөрөл олгоод байна.

Улсын онцгой комиссын даргын 2021 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн 31 дүгээр тушаалаар “Тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохицуулах түр журам” батлагдсантай холбогдуулан хилийн чанадаас ирэх иргэдийг зориулалтын байранд 7 хоног тусгаарлах горим хэрэгжиж эхэлсэн. Мөн коронавируст халдварын эсрэг вакцины бүрэн тун авснаас хойш 14 хоногийн хугацаа өнгөрсөн болон коронавируст халдвар авч, эдгэрсэн хүнийг тусгаарлахгүй байхаар шийдвэрлэсэн.

Захиалгат нислэгээр ирсэн иргэдийг тусгаарлах зориулалтаар 14 зочид буудлыг тусгаарлан ажиглах байраар ашиглаж байгаа бол нөөцөд 11 зочид буудлын 531 өрөө, 932 орыг бэлтгээд байна. Тусгаарлан ажиглах байрыг иргэдэд сонголттой болгох зорилгоор ялгаатай үнэтэй байруудын сонголтуудыг бий болгож, мэдээллийг иргэдэд нээлттэй хүргэх зорилгоор www.tabinfo.mn цахим хуудсыг ажиллуулж байна.

3.7. Хилийн ачаа тээвэр, боомтын үйл ажиллагаа

Монгол Улсад 2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр коронавируст халдварын анхны тохиолдол бүртгэгдэж, Монгол-Хятадын хилийн авто замын бүх боомтоор нэвтрэх ачаа тээврийн хөдөлгөөн огцом буурсан. Хятадын талтай дипломат шугамаар идэвхтэй харилцсаны дүнд хоёр улсын хилийн авто замын бүх боомтоор хил нэвтэрч байгаа тээврийн хэрэгслийн тоо 2021 оны 3 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл харьцангуй тогтвортой байсан. Тухайлбал, Гашуунсухайт боомтоор өдөрт дунджаар 500 нүүрсний машин, 80 зэсийн баяжмалын машин, Шивээхүрэн боомтоор өдөрт дунджаар 400 нүүрс тээврийн хэрэгсэл хил нэвтэрч байсан.

Харин “Оюу толгой” ХХК-ийн ажилтнаас коронавируст халдвар илэрсэнтэй холбоотойгоор Хятадын талаас Гашуунсухайт боомтоор зэсийн баяжмал тээвэрлэх авто машиныг хилээр оруулахыг түр хязгаарлаж байгаагаа мэдэгдэж, тус боомтоор зэсийн баяжмалын экспорт 3 дугаар сарын 15-ны өдрөөс зогсож, нүүрсний экспорт өдөрт дунджаар 50 машин хил нэвтэрч, огцом буураад байна.

Уг асуудлыг шийдвэрлэх зорилгоор Хятадын талтай харилцсаны дүнд Монгол, Хятадын Гадаад харилцааны яамд хоорондын цахим уулзалтын механизмын III уулзалтыг 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан. Энэхүү уулзалтаар Бүгд Найрамдах Хятад Ард Улстай хиллэдэг боомтуудын бүсэд халдвар хамгааллын дэглэмийг сайжруулж, жолооч, хил, боомтын ажилтнуудыг вакцинд хамруулах ажлыг эрчимжүүлж байгаа талаар мэдээлж, боомтуудын үйл ажиллагааг хэвийн болгох санал дэвшүүлэн холбогдох чиглэлээр ажиллаж байна.

Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Бургастай-Лаоомяо боомтыг 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс байнгын ажиллагаанд шилжүүлэхээр Хятадын талтай тохиролцсон. Мөн Булган-Такашикэн боомтыг 2021 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс 2021 оныг дуустал бямба, ням гарагт нэмэлтээр ажиллуулахаар тохиролцож, хэрэгжүүлж эхлээд байна. Ингэснээр Булган боомтоор өдөрт дунджаар нүүрс экспортын 80-100 машиныг толгой-чиргүүл солих зарчмаар хилийн дундын бүсэд солилцож байна.

Замын-Үүд төмөр замын боомт хуваарийн дагуу ажиллаж, Хятадын талд байгаа 70 жолооч хилийн дундын бүсэд авто машины жолооч солилцох байдлаар улс хоорондын тээвэрлэлт хэвийн явж байна. Мөн Бичигт боомтоор “Дачин тамсаг” ХХК-ийн газрын тос өдөрт дунджаар 30-50 машин, Ханги боомтоор нүүрс өдөрт дунджаар 50-60 машин, Баянхошуу боомтоор “Дачин тамсаг” ХХК-ийн газрын тос өдөрт дунджаар 30-50 машин улсын хилээр нэвтэрч, нөхцөл байдал хэвийн байна.

Боршоо авто замын боомтыг 2021 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс сар бүрийн хоёр болон дөрөв дэх долоо хоногт нээн ажиллуулж, зөвхөн шатахуун, малын тэжээл тээвэрлэх авто машиныг улсын хилээр нэвтрүүлж байна. Мөн Цагааннуур авто замын боомтыг сар бүрийн хоёр болон дөрөв дэх долоо хоногт, Эрээнцав төмөр замын боомтыг сар бүрийн нэг болон гурав дахь долоо хоногт нээн ажиллуулж, зөвхөн нефть бүтээгдэхүүн, малын тэжээл улсын хилээр нэвтрүүлж байна.

Алтанбулаг авто замын боомтыг 2 дугаар сарын 23-ны өдрөөс байнгын ажиллагаанд шилжүүлж, гадаад тээвэрлэгчийг нутгийн гүн рүү нэвтрүүлэхгүй, толгой-чиргүүл солих байдлаар тээвэр зохион байгуулалтыг гүйцэтгэж байна.

3.8. Нийгмийн сэтгэл зүйг дэмжих соён гэгээрүүлэх болон соёл урлагийн цахим арга хэмжээ

Бүх нийтийн хатуу хөл хорио тогтоосон хугацаанд нийгмийн сэтгэл зүйг дэмжих хүрээнд соёл, урлагийн цахим арга хэмжээг зохион байгуулж Үндэсний урлагийн их театр, Дуурь бүжгийн эрдмийн театр, Улсын филармони, Монголын Үндэсний номын сан, Хүүхдийн номын сан, Монголын Үндэсний музей, Чойжин ламын сүм музей, Уран зургийн галерей зэрэг нийт 14 соёл, урлагийн байгууллага өргөн нэвтрүүлгийн 13 сувгаар 28 контентыг хүргэж ажилласан байна.

3.9. “Залуус I, II, III орон сууцны хороолол” төсөл

Нийслэлийн Хан-Уул дүүргийн 21 дүгээр хороонд байрлах “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн 57 га газарт, Морингийн даваанд нийт 3,000 орчим өрхийг орлогод нийцсэн орон сууцаар хангах “Залуус 1” хорооллыг байгуулахаар төлөвлөж байна.

Энэ хүрээнд орон сууцны хорооллын техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа, эх загвар зургийг 2021 оны 2 дугаар улиралд, 2021 оны 3, 4 дүгээр улиралд хорооллын эхний ээлжийн гадна инженерийн шугам, сүлжээний зураг төсөл, эхний ээлжийн ажлын зураг төслийг боловсруулахаар төлөвлөж байна. Боловсруулсан зураг төслийн дагуу 2022 онд хорооллын инженерийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэх юм.

“Залуус 1” хорооллын орон сууцны бүтээн байгуулалтыг давтан хэрэглэх нэг маягийн зурагт тулгуурлан төрөөс газар, дэд бүтцийн бүтээн байгуулалт, ипотекийн хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр хувийн хэвшилтэй хамтран төр, хувийн хэвшлийн зохистой түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх замаар иргэдийг төлбөрийн чадварт нийцсэн, инженерийн дэд бүтцэд холбогдсон орон сууцаар хангах зорилт дэвшүүлж байгаа болно.

-----oOo-----